

	МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ ЛАБОРАТОРИЙН ЖУРАМ	МТЛЖ.6.2 Хувилбар № 3	Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн 2020 оны.....-р сарын-ны өдрийнтоот тушаалын-р хавсралт
Гарчиг (MNS ISO/IEC 17025:2018)		1. Ажилтныг сонгох, сургах, хяналт тавих, эрх олгох, ур чадварт үнэлгээ хийх журам	

АЖИЛТНЫГ СОНГОХ, СУРГАХ, ХЯНАЛТ ТАВИХ, ЭРХ ОЛГОХ, УР ЧАДВАРТ ҮНЭЛГЭЭ ХИЙХ ЖУРАМ

Баримт бичгийн нэр: МТЛЖ	Боловсруулсан:	Өөрчлөлт оруулсан:	Хянасан:
Албан тушаал	УМЭАЦТЛ.Чанарын менежер	Лабораторийн эрхлэгч	МЭ-ийн газрын дарга
Нэр	Ч.Нямцэнгэл	М.Бүтэнжаргал	М.Молорчимэг
Огноо	2019.09.18	2020.06.25	2020.07.02
Гарын үсэг			

ХЯНАЖ ШИНЭЧИЛСЭН БҮРТГЭЛ

ХЯНАЛТТАЙ ХУВЬ

Хэвлэсэн огноо: 2020.06.29

Хуудас 1 - 10

	МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ ЛАБОРАТОРИЙН ЖУРАМ	МТЛЖ.6.2 Хувилбар № 3	Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн 2020 оны.....-р сарын-ны өдрийнтоот тушаалын-р хавсралт
Гарчиг (MNS ISO/IEC 17025:2018)		1. Ажилтныг сонгох, сургах, хяналт тавих, эрх олгох, ур чадварт үнэлгээ хийх журам	

Хувилбар	Баталсан огноо	Өөрчлөлт оруулсан хүний /овог,нэр, албан тушаал/	Өөрчлөлтийн товч утга
1	20/04/2018	Ж.Сундуй / Лабораторийн эрхлэгч /	Анхны хувилбар
2	09/10/2019	Ч.Нямцэнгэл /УМЭАЦТЛ-ийн Чанарын менежер/	MNS ISO/IEC 17025:2018 стандартын шаардлагад нийцүүлэн энэхүү журмын 2, 3, 4, 5-р зүйл, мөн журмын хавсралт, 1-4 дүгээр маягыг шинээр боловсруулав.
3	03/08/2020	М.Бүтэнжаргал /Лабораторийн эрхлэгч / Ч.Нямцэнгэл /УМЭАЦТЛ-ийн Чанарын менежер/	Сүлжээ лабораториудын түвшинд нийцүүлэн өөрчлөлт оруулав.

	<p align="center">МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ ЛАБОРАТОРИЙН ЖУРАМ</p>	<p align="center">МТЛЖ.6.2 Хувилбар № 3</p>	<p>Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн 2020 оны.....-р сарын-ны өдрийнтоот тушаалын-р хавсралт</p>
<p align="center">Гарчиг (MNS ISO/IEC 17025:2018)</p>		<p align="center">1. Ажилтныг сонгох, сургах, хяналт тавих, эрх олгох, ур чадварт үнэлгээ хийх журам</p>	

**АЖИЛТНЫГ СОНГОХ, СУРГАХ, ХЯНАЛТ ТАВИХ, ЭРХ ОЛГОХ,
УР ЧАДВАРТ ҮНЭЛГЭЭ ХИЙХ ЖУРАМ**

1.НИЙТЛЭГ ЗҮЙЛ

Энэхүү журам нь ажилтан сонгох, шинээр авах, тэдний мэдлэг боловсрол, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, хөрвөн ажиллах чадварыг сайжруулах зорилгоор сургах, эрх олгох, ажилтанд хяналт тавьж, үнэлэхтэй холбоотой харилцааг зохицуулна.

2.ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү журмыг лаборатори үйл ажиллагаандаа чанд мөрдөнө.

3.НЭР ТОМЪЁО, ТОДОРХОЙЛОЛТ

Эмч, ажилтан - Лабораторийн үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардагдах мэргэжлийн, ур чадвартай үндсэн болон гэрээт ажилтан

Дадлагажуулагч– Тухайн ажлын байранд ажиллах ажилтанд аюулгүй байдал, багаж төхөөрөмж ажиллуулах, шинжилгээний дэс дараалал зэрэг чадварыг эзэмшүүлэх


4.ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

А.Газрын дарга

- Сул орон тоонд сонгон шалгаруулалт зарлуулах;
- Газрын даргын зөвлөлийн шийдвэрийг үндэслэн тушаал гаргах;

Б. Лабораторийн эрхлэгч /чанарын менежер/

- Хэрэгцээт эмч, ажилтны захиалга оруулах;
- Албан тушаалын тодорхойлтын шаардлагыг хангасан мэргэжилтэнг газрын даргын зөвлөлд санал оруулах;
- Албан тушаалын тодорхойлтын шаардлагыг хангасан эсэхэд дүгнэлт гаргах;
- Сорилтын тайланд санал зөвлөмж бичих, тохирлын тухай мэдэгдэл гаргах, тайлагнах;
- Өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавих, хариуцлага тооцох санал оруулах;
- Лабораторийн менежментийн тогтолцооны хүрээнд тусгасан журмыг танилцуулах;
- Сургалтын төлөвлөгөө боловсруулах;
- Сургалт зохион байгуулах, хяналт тавих;
- Эмч, ажилтанд ажиллах эрх олгох, санаачлага гаргаж санал, зөвлөмж оруулах;
- Эмч, ажилтны ур чадвар, хариуцлагын асуудлаар газрын даргын зөвлөлд, удирдлагад санал оруулах;
- Эмч ажилтны албан тушаалын тодорхойлтын шаардлагыг тодорхойлох, мөрдүүлэх, үйл ажиллагаанд хяналт тавих;

	<p align="center">МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ ЛАБОРАТОРИЙН ЖУРАМ</p>	<p align="center">МТЛЖ.6.2 Хувилбар № 3</p>	<p align="center">Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн 2020 оны.....-р сарын-ны өдрийнтоот тушаалын-р хавсралт</p>
<p align="center">Гарчиг (MNS ISO/IEC 17025:2018)</p>		<p align="center">1. Ажилтныг сонгох, сургах, хяналт тавих, эрх олгох, ур чадварт үнэлгээ хийх журам</p>	

- Лабораторийн хэмжээнд сорилт, туршилтын үр дүн нэгтгэх, тайлагнах санал зөвлөмж бичих;

В. Техникийн менежер

- Сорилт шинжилгээний ажлыг итгэмжлэлийн хүрээний тодорхойлолтод заагдсан стандарт арга, аргачлалын дагуу үнэн зөв хийж гүйцэтгэх болон сорилтын үр дүнг тайлагнахад хяналт тавих;
- Шинжилгээний аргын болон багаж төхөөрөмжийн стандарт ажлын зааврын боловсруулалтанд хяналт тавих;
- Лабораторийн техникийн аюулгүй ажиллагаа, бүрэн бүтэн байдлыг хариуцах;
- Засвар үйлчилгээг хийж гүйцэтгүүлэх ажлыг хариуцах.
- Бодис урвалжийн хадгалалт, хаягжуулалт, аюулгүй ажиллагааг хянах;

Г. Газрын даргын зөвлөл:

- Хүний нөөцийн бодлого чиглэлийг тодорхойлох дүгнэлт гаргах;
- Тулгамдаж буй асуудлаар хуралдаж хурлын шийдвэрт тусгах;
- Зөвшөөрөл олгох, хариуцлага тооцох;

Д. Эмч, ажилтан:

- Удирдлагаас ирсэн үүрэг даалгаврыг цаг тухайд нь шударгаар биелүүлэх;
- Сорилтын арга боловсруулах, баталгаажуулах, нотлох, тайлагнах;
- Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг хангаж ажиллах;
- Лабораторийн дүрэм, журам, заавар зөвлөмжийг мөрдөж ажиллах;

5.ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

5.1 Ур чадварт тавих шаардлагыг тодорхойлох

- 5.1.1 Тухайн чиглэлээр их дээд сургууль төгссөн байх;
- 5.1.2 Үйлдвэрлэлд хоёроос доошгүй жил ажилласан байх, хэрэв шинэ төгсөгч бол голч дүн нь 2.5-аас дээш байх;
- 5.1.3 Гадаад хэлний зохих түвшиний мэдлэгтэй байх /англи, орос гм/;
- 5.1.4 Компьютерийн өргөн хэрэглээний программ эзэмшсэн байх;
- 5.1.5 Албан бичиг боловсруулах болон Монгол хэлний зөв бичгийн дүрэм бүрэн эзэмшсэн, бичгийн хэлбэр зөв, сайн байх;
- 5.1.6 Аливаа ажлыг дүгнэж, цэгнэх, дүгнэлт гаргах чадвартай байх;
- 5.1.7 Багаар ажиллах чадвартай байх;
- 5.1.8 Гэмт хэрэгт холбогдоогүй байх;
- 5.1.9 Үнэнч шударга ажиллах чадамжтай байх;

	<p align="center">МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ ЛАБОРАТОРИЙН ЖУРАМ</p>	<p align="center">МТЛЖ.6.2 Хувилбар № 3</p>	<p align="center">Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн 2020 оны.....-р сарын-ны өдрийнтоот тушаалын-р хавсралт</p>
<p align="center">Гарчиг (MNS ISO/IEC 17025:2018)</p>		<p align="center">1. Ажилтныг сонгох, сургах, хяналт тавих, эрх олгох, ур чадварт үнэлгээ хийх журам</p>	

- 5.1.10 Ёс суртахууны болон элдэв муу зуршилгүй байх;
- 5.1.11 Ажлын ачаалал даах чадамжтай байх;
- 5.1.12 Өндөр мэдрэг багажтай харьцан ажилладаг бол давуу тал болно;

5.2 Эмч, ажилтан сонгох

- 5.2.1 Ажил горилогчийн ирүүлсэн материалыг удирдлагад танилцуулж сонгогдсон иргэнийг дуудна.
- 5.2.2 Сонгогдсон иргэнтэй эхний шатны ярилцлагыг хүний нөөцийн ажилтан, лабораторийн эрхлэгч /чанарын менежер/ нар хийнэ. Шаардлага хангасан гэж үзвэл газрын даргад танилцуулж, даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ.
- 5.2.3 Ажилтан сонгон шалгаруулах шалгалтыг бичгээр тест хэлбэрээр авна.
- 5.2.4 Ажилтан энэхүү журмын 5.1 дэх хэсэгт заасан шаардлагыг хангасан байна.

5.3 Эмч, ажилтныг сургах

- 5.3.1 Шинэ ажилтанд лабораторийн биоаюулгүйн ажиллагааны зааврыг танилцуулж, “Биоаюулгүйн ажиллагааны заавартай танилцсан бүртгэл” хавсралт 1-д үзүүлсэн маягтын дагуу бүртгэл хөтөлнө.
- 5.3.2 Тухайн ажлын байранд 3-6 сарын хугацаанд дадлагажуулан сургана.
- 5.3.3 Цаашид хэрэгцээ, шаардлагын дагуу зохих сургалт, төсөл хөтөлбөрт хамруулж, “Сургалтын захиалга, тайлан” хавсралт 2,3-д үзүүлсэн маягтын дагуу бүртгэл хөтөлнө.

5.4 Эмч, ажилтанд хяналт тавих

- 5.4.1 Шинээр орсон ажилтныг дадлагажуулагч нь өдөр тутмын шинжилгээний үйл ажиллагааны дэс дараалал болон түүнд ашиглагдаж байгаа эм урвалжтай хэрхэн зөв харьцаж байгаа эсэхэд хяналт тавина.
- 5.4.2 Шинжилгээнд ашиглагдаж байгаа багаж төхөөрөмжийг зөв ашиглаж, аюулгүй ажиллагааны зааврыг мөрдөж байгаа эсэхэд хяналт тавина.

5.5 Эмч, ажилтанд ажил гүйцэтгэх эрх олгох

- 5.5.1 Ажилтан дадлагын хугацаа дуусгавар болсоны дараа, онол практикын шалгалт авч үнэлгээ нь 80%-аас дээш оноо авсан, сахилгын шийтгэл хүлээгээгүй тохиолдолд газрын даргын зөвлөлөөр хэлэлцүүлэн тухайн ажлын байранд үндсэн ажилтнаар ажиллах эрхийг олгоно.
- 5.5.2 Шаардлага хангасан шинжээч эмчид дараах эрхийг олгоно.
 - а. Шинжилгээний сорилт, туршилтын арга боловсруулах, өөрчлөлт оруулах, баталгаажуулах, нотлох;

	<p align="center">МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ ЛАБОРАТОРИЙН ЖУРАМ</p>	<p align="center">МТЛЖ.6.2 Хувилбар № 3</p>	<p>Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн 2020 оны.....-р сарын-ны өдрийнтоот тушаалын-р хавсралт</p>
<p align="center">Гарчиг (MNS ISO/IEC 17025:2018)</p>			<p align="center">1. Ажилтныг сонгох, сургах, хяналт тавих, эрх олгох, ур чадварт үнэлгээ хийх журам</p>


5.6. Тохирлын тухай мэдэгдэл хийх ажилтанд тавих шаардлага

- 5.6.1. Лаборатори, сургалт эрдэм шинжилгээний байгууллагад 5-аас дээш жил ажилласан байх;
- 5.6.2. Лабораторийн шинжилгээ, сорилт туршилт, эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэж байсан дадлага туршлагатай байх;
- 5.6.3. Туршилт, сорилын үйл явц, дараалал, мөн чанарыг тодорхойлж чаддаг, төсөл хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлсэн туршлагатай байх;
- 5.6.4. Лабораторийн итгэмжлэлийн хүрээний тодорхойлолтод заагдсан (гоц халдварт, халдварт, халдваргүй өвчин, мал эмнэлгийн ариун цэвэр, хүнсний аюулгүй байдал г.м) шинжилгээний арга, аргачлалыг тодорхой түвшинд эзэмшсэн, гадаад дотоодын төрөлжсөн сургалтанд хамрагдсан байх;
- 5.6.5. Гадаад хэлний зохих түвшний мэдлэгтэй байх;
- 5.6.6. Шаардлага хангасан удирдах ажилтанд дараах эрхийг олгоно.
 - a) Тохирлын тухай мэдэгдэл гаргах;
 - b) Байгууллагын хэмжээнд сорилт туршилтын үр дүнд дүн шинжилгээ хийх, санал зөвлөмж хүргүүлэх;
 - c) Сорилт туршилтын ажлын удирдамж боловсруулах, гүйцэтгэх, үр дүнг тайлагнах, зөвшөөрлийг холбогдох эмч ажилтанд даалгах;

5.7. Эмч, ажилтны ур чадварт хяналт үнэлгээ хийх

- 5.7.1 Тухайн ажилтны ур чадварыг үнэлэхдээ гардан шинжилгээ хийлгэнэ.
- 5.7.2 Гардан шинжилгээ хийлгэхдээ хяналтын дээж ашиглана.
- 5.7.3 Тухайн хийгдэх шинжилгээний бүх процессыг сайн мэддэг шинжээч эмчийн хяналтан доор гардан шинжилгээг явуулна.
- 5.7.4 Эзэмшвэл зохих мэдлэг үнэлэх тест, ур чадварыг үнэлэх дадлагын сорил зэргийг багтаасан үнэлгээний хуудсыг боловсруулан шалгалт авна. “*Үнэлгээний хуудас*” хавсралт 4-д үзүүлсэн маягтын дагуу бүртгэл хөтөлнө.

.

	МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ ЛАБОРАТОРИЙН ЖУРАМ	МТЛЖ.6.2 Хувилбар № 3	Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн 2020 оны.....-р сарын-ны өдрийнтоот тушаалын-р хавсралт
Гарчиг (MNS ISO/IEC 17025:2018)		1. Ажилтныг сонгох, сургах, хяналт тавих, эрх олгох, ур чадварт үнэлгээ хийх журам	

“Ажилтныг сонгох, сургах, хяналт тавих, эрх олгох, ур чадварт үнэлгээ хийх журам. МТЛЖ.6.2.5.-ын 1 дүгээр хавсралт

Маягт - 01

БИОАЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРТАЙ ТАНИЛЦСАН БҮРТГЭЛ

№	Шинэ ажилтаны /Овог.нэр/	Заавартай танилцаж судалсан эсэх	Огноо	Гарын үсэг
1				
2				
3				

Бүртгэл хийсэн:...../...../

“Ажилтныг сонгох, сургах, хяналт тавих, эрх олгох, ур чадварт үнэлгээ хийх журам. МТЛЖ.6.2.5.-ын 2 дугаар хавсралт

Маягт - 02

СУРГАЛТЫН ЗАХИАЛГА

№	Сургалтын мэдээлэл			Сургалтанд оролцогч		Сургалтын зардал	
	Нэр	Хугацаа	Зохион байгуулагчийн нэр	Тоо	Лаб-оос санал болгосон ажилтны нэр, албан тушаал	Зардал /төг/	Эх үүсвэр
1							
2							
3							
4							
5							

Захиалга өгсөн:/...../

	МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ ЛАБОРАТОРИЙН ЖУРАМ	МТЛЖ.6.2 Хувилбар № 3	Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн 2020 оны.....-р сарын-ны өдрийнтоот тушаалын-р хавсралт
Гарчиг (MNS ISO/IEC 17025:2018)			1. Ажилтныг сонгох, сургах, хяналт тавих, эрх олгох, ур чадварт үнэлгээ хийх журам

“Ажилтныг сонгох, сургах, хяналт тавих, эрх олгох, ур чадварт үнэлгээ хийх журам.

МТЛЖ.6.2.5.-ын 3 дугаар хавсралт

Маягт - 03


СУРГАЛТЫН ТАЙЛАН

..... оны сарын өдрийн байдлаар

№		Ажилтны мэдээлэл		Сургалтын мэдээлэл				Сургалтын зардал /төг/			Сургалтын үр дүнгийн мэдээлэл		
нэгдсэн	тус бүрийн	Нэр	Албан тушаал	Нэр	Гэрчилгээний №	Хугацаа	Зохион байгуулагчийн нэр	Ажилтнаас	Лаб-оос	Бусад	тайлаг-насан огноо	Танилцуулга, хичээлийн огноо	Ажилд нэвтрүүлсэн эсэх
1	Нэг. Лабораторийн нэр:												
2	1												
3	2												
4	Дөрөв . Лабораторийн нэр:												
5	1												
6	2												
7	Долоо. Бусад												
8	1												
9	2												

Тайлан гаргасан:/...../

Тайлан нэгтгэсэн:/...../

	МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ ЛАБОРАТОРИЙН ЖУРАМ	МТЛЖ.6.2 Хувилбар № 3	Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн 2020 оны.....-р сарын-ны өдрийнтоот тушаалын-р хавсралт
Гарчиг (MNS ISO/IEC 17025:2018)		1. Ажилтныг сонгох, сургах, хяналт тавих, эрх олгох, ур чадварт үнэлгээ хийх журам	

“Ажилтныг сонгох, сургах, хяналт тавих, эрх олгох, ур чадварт үнэлгээ хийх журам.

МТЛЖ.6.2.5.-ын 4 дүгээр хавсралт

Маягт - 04

ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Дадлагажуулагч:

(овог нэр, албан тушаал)

Дадлагажигч:

(овог нэр, албан тушаал)

НЭГ. ЭЗЭМШВЭЛ ЗОХИХ МЭДЛЭГ ҮНЭЛЭХ БИЧГИЙН ТЕСТ

Зааварчилгаа: Асуултуудыг уншаад тодруулах шаардлагатай бол үнэлгээний ажилтнаас тодруулж асууна уу. Үнэлгээний ажилтан эхэл гэх хүртэл эхэлж болохгүй. Олон сонголттой асуултын хариултыг дугуйлна уу. Нөхөж бичих бол хариултаа нэг үг эсвэл өгүүлбэрээр өгөгдсөн зайд тохируулж хариулна уу.

Сорилтын хугацаа: минут

Эзэмшвэл зохих мэдлэгийг үнэлэх шалгуур асуултууд	Хариултууд	Үнэлгээний ажилтан	
		ТИЙМ	ҮГҮЙ
Асуулт 1.	A. ... B. ... C. ... D. ...		
Асуулт 2.Г.М гэнэ.		

ХОЁР. ЭЗЭМШВЭЛ ЗОХИХ УР ЧАДВАРЫГ ҮНЭЛЭХ ДАДЛАГЫН СОРИЛ

Зааварчилгаа: Үнэлгээний ажилтан эхэл гэх хүртэл эхэлж болохгүй. Гүйцэтгэх ажлын талаар шаардлагатай бол үнэлгээний ажилтнаас тодруулж асууна уу. Ажлаа эхлэхээс өмнө шаардлагатай хэрэгслийн бүрэн байдлыг шалгана уу. Ажлаа гүйцэтгэж байх үедээ хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааг баримтлан ажиллана уу.

Гүйцэтгэх ажил:


.....

(ажлын нэр, холбогдох стандартын дугаар)

Ур чадварыг үнэлэх шалгуур үзүүлэлт	Үнэлгээний ажилтан	
	ТИЙМ	ҮГҮЙ
1. Стандарт ажлын зааврыг баримталж байгаа эсэх		
2. ХАБ-ын журмыг баримталж байгаа эсэх		
3. Хугацаа баримталж байгаа эсэх		
4. Бусад		

ГУРАВ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮР ДҮН

Суралцагч бүх асуултанд “ТИЙМ” гэсэн тэмдэглэгээ авсан бол “Хангалттай” гэж үзнэ. Бүх шалгуурын 20%-д “ҮГҮЙ” гэсэн тэмдэглэгээ авсан бол үнэлгээний ажилтны нэмэлтээр асуусан 3 асуултанд зөв хариулж, үнэлгээгээ ахиулж болно. Бүх шалгуурын 20%-иас дээш “ҮГҮЙ” гэсэн тэмдэглэгээ авсан бол “Хангалтгүй” гэж үзнэ.

	<p align="center">МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ ЛАБОРАТОРИЙН ЖУРАМ</p>	<p align="center">МТЛЖ.6.2 Хувилбар № 3</p>	<p>Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн 2020 оны.....-р сарын-ны өдрийнтоот тушаалын-р хавсралт</p>
<p align="center">Гарчиг (MNS ISO/IEC 17025:2018)</p>			<p align="center">1. Ажилтныг сонгох, сургах, хяналт тавих, эрх олгох, ур чадварт үнэлгээ хийх журам</p>

Нэмэлт асуулт 1.....

Хариулт 1.....

Нэмэлт асуулт 2..... Хариулт 2

Нэмэлт асуулт 3..... Хариулт 3

Үнэлгээний ажилтны санал

.....
.....

Үнэлгээний ажилтан:/...../

Суралцагч:/...../

Огноо